

БАТЛАВ.

МОНГОЛЫН ДААМЫН ХОЛБООНЫ

“ГАЦУУРТ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

ЕРӨНХИЙЛӨГЧ О.МЭНДБАЯР

Н.НАРАНЧИМЭГ

**“ГАЦУУРТ” КОМПАНИЙН НЭРЭМЖИТ 2016 ОНЫ ӨСВӨР ҮЕИЙН  
УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

**Нэг. Нийтлэг зүйл**

- 1.1. Тэмцээний зорилго нь 100 буудалт даамын спортыг сурталчилж хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, 2016 оны “Өсвөрийн улсын аварга”-ыг тодруулах, Ази тивийн аварга шалгаруулах шигшээ тэмцээн болон “Азийн хүүхдүүд” наадмын даамын тэмцээнд оролцох тамирчдыг сонгон шалгаруулахад оршино.
- 1.2. Тэмцээн охид, хөвгүүдийн **5-7, 8-10, 11-13, 14-16** насны ангиллаар **нээлттэй** явагдана.
- 1.3. Төрлүүд: **100 буудалт даамын үндсэн болон блиц, 64 буудалт даамын үндсэн болон блиц, турк даам** гэсэн 5 төрлөөр зохиогдоно. 64 буудалт даам нь Бразил буюу олон улсын даамын дүрмээр (100 буудалттай ижил дүрэм) тоглоно.
- 1.4. Тэмцээн Монголын даамын холбооны тэмцээний дүрмийн дагуу явагдана.
- 1.5. Тэмцээний дүнг тамирчдын дотоод, гадаад чансаа бодох, зэрэг цол олгоход тооцно.

**Хоёр. Тэмцээний журам**

- 2.1. Тэмцээн **2016 оны 3 дугаар сарын 29-нөөс 4 дүгээр сарын 3-ны өдрүүдэд** явагдана.
- 2.2. Тэмцээнийг Монголын даамын холбоо зохион байгуулж, шүүгчдийн бүрэлдэхүүнийг томилно.
- 2.3. Тамирчдын бүртгэлийг **оролцох эрхийн тоог гүйцтэл эсвэл 2016 оны 3 дугаар сарын 10-ныг хүртэл** хүлээн авна.
- 2.4. **Тэмцээний хураамж төлж, тэмцээнд оролцох эрхийг баталгаажуулсан тоглогчид мандат олгоно.**
- 2.5. Тэмцээний хураамжийг төлж, тэмцээнд бүртгүүлэх, бүртгэлээ шалгах зэргийн талаар [www.mondaam.mn](http://www.mondaam.mn) вэбсайтаас таницана уу.
- 2.6. 100 буудалт даамын үндсэн тэмцээний цагийн хяналт 11-13, 14-16 насны ангилалд талдаа **1 цаг**, 8-10 насны ангилалд талдаа **40 минут**, 5-7 насны ангилалд талдаа **30 минут** байна.
  - 100 буудалт-блиц **5мин+1сек**

- 64 үндсэн, турк даам– **15мин**
  - 64 блиц – **3мин+1сек**
- 2.1. 100 буудалт даамын үндсэн төрөл швейцарь системээр 9 өрөг, бусад тэмцээнүүд мөн швейцарь системээр 7 тоглож дүнг гаргана.
  - 2.2. Тоглогчдыг хожлын тоогоор цуваагаар байр эзлүүлэн, хожлын тоо тэнцсэн үед дараах шалгуурыг баримтална. Үүнд:
    1. Швейцарь системийн Бухгольцын коэффициент
    2. Швейцарь системийн Солкофын коэффициент (хоёр талаас нь -1,-2...)

### **Гурав. Шагнал, урамшуулал**

- 3.1. Тэмцээнд эхний 3 байр эзэлсэн тамирчдыг алт, мөнгө, хүрэл медаль, мөнгөн шагналаар урамшуулна.
- 3.2. Ангилал тус бүрт эхний 5 байрт шалгарсан тамирчдад Азийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх олгоно.
- 3.3. 64, 100 буудалт даамын 11-13, 14-16 насны ангилалд медаль хүртсэн тамирчид 2016 оны 7 дугаар сард Якут улсад зохиогдох **“Азийн хүүхдүүд 2016”** спортын наадамд оролцох тамирчин шалгаруулах сорилт тэмцээнд оролцох эрх авна. Холбооны чансааг харгалзан 2 хүртэл тамирчинд сорилтод оролцох эрх олгож болно. Сорилт тэмцээний удирдамжийг жич гаргах ба 100 буудалт даамын төрөлд эрэгтэй, эмэгтэй тус бүр 2, 64 буудалт даамын төрөлд эрэгтэй, эмэгтэй тус бүр 1 тамирчин шалгаруулна.
- 3.4. Тамирчин авбал зохих онооноос дараах болзлыг хангасан тохиолдолд спортын цол, зэргийг биелүүлнэ. Үүнд:

#### Спортын зэргийн болзол

(100, 64, Турк даамын үндсэн төрөлд дараахь хожил авч зэргийн болзол биелүүлнэ)

	<b>5-7 нас</b>	<b>8-10 нас</b>	<b>11-13 нас</b>	<b>14-16 нас</b>
III зэрэг	12-15 оноо	10-12 оноо	8-10 оноо	6-7 оноо
II зэрэг	16 ба түүнээс дээш	13-15 оноо	11-13 оноо	8-10 оноо
I зэрэг		16 ба түүнээс дээш	14-16 оноо	11-13 оноо
Дэд мастерын 1 балл			17 ба түүнээс дээш	14-16 оноо
Дэд мастерын 2 балл				17 ба түүнээс дээш

## Дөрөв. Тэмцээний хуваарь

Гацуурт ХХК-ийн нэрэмжит Өсвөр үеийн УАШТ 2016

	Цаг	5-7	8-10	11-13	14-16
3 сарын 29	15:00	Техникийн зөвлөгөөн			
3 сарын 30	10:00	100Y - 1-р тойрог			
	11:30	100Y - 2-р тойрог	100Y - 2-р тойрог		
	13:00	100Y - 3-р тойрог	100Y - 3-р тойрог	100Y - 2-р тойрог	100Y - 2-р тойрог
	14:30	100Y - 4-р тойрог	100Y - 4-р тойрог		
	16:00	100Y - 5-р тойрог	100Y - 5-р тойрог	100Y - 3-р тойрог	100Y - 3-р тойрог
3 сарын 31	10:00	100Y - 6-р тойрог	100Y - 6-р тойрог	100Y - 4-р тойрог	100Y - 4-р тойрог
	11:30	100Y - 7-р тойрог	100Y - 7-р тойрог		
	13:00	100Y - 8-р тойрог	100Y - 8-р тойрог	100Y - 5-р тойрог	100Y - 5-р тойрог
	14:30	100Y - 9-р тойрог	100Y - 9-р тойрог		
	16:00	Шагнал гардуулах		100Y - 6-р тойрог	100Y - 6-р тойрог
4 сарын 1	10:00	100Б	100Б	100Y - 7-р тойрог	100Y - 7-р тойрог
	13:00			100Y - 8-р тойрог	100Y - 8-р тойрог
	14:00	64Б	64Б		
	16:00			100Y - 9-р тойрог	100Y - 9-р тойрог
	18:30	Шагнал гардуулах			
4 сарын 2	10:00	64Y - 1-р тойрог			
	10:45	64Y - 2-р тойрог			
	11:30	64Y - 3-р тойрог			
	12:15	64Y - 4-р тойрог			
	13:00	64Y - 5-р тойрог			
	15:00	64Y - 6-р тойрог			
	16:30	64Y - 7-р тойрог			
	18:00	Шагнал гардуулах			
	18:30			64Б	64Б
4 сарын 3	10:00	Турк даам	Турк даам	100Б	100Б
	14:00			Турк даам	Турк даам
	18:30	Шагнал гардуулах			

Тэмдэглэгээ: 100Y = 100 буудалт даамын үндсэн төрөл (цагийн хяналт 1 цаг)

100Б = 100 буудалт даамын блиц төрөл (5'+1")

64Y = 64 буудалт даамын үндсэн төрөл (15')

64Б = 64 буудалт даамын блиц төрөл (3'+1")

МОНГОЛЫН ДААМЫН ХОЛБОО

Харилцах утас: 99164205, Email: [daam@mondaam.mn](mailto:daam@mondaam.mn), Web: [www.mondaam.mn](http://www.mondaam.mn)